



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 477

Улаанбаатар хот

Гадаадад сургалтын төрийн сангийн  
зээлээр суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн яамны захиалгаар Булганы Нарангэрэлийг АНУ-ын Devry-н их сургуулийн магистрантурт Санхүү, бүртгэлийн менежментийн чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар суралцуулсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР